



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/29/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2025 он	ТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: "Бэйкер Тилли Далайван аудит" ХХК Утас: 99396969 Цахим хаяг: urtaa6969@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	4-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6-11
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	12-16
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	13-14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14-16
4. Аудитын тайлан	16-19
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. Аудитын илрүүлэлт	19-20
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БЕГ	Боловсролын ерөнхий газар
НА	Нийцлийн аудит
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТАГ	Төрийн аудитын газар
ТБОНӨХБАҮХА худалдах авах тухай	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр ажил үйлчилгээ худалдах авах тухай
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

Г МАНДАЛ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 2 ДУГААР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ц.ЭРДЭНЭСАРАН ТАНАА

2025. 02. 25 № СМ-2025/29-НН-СМ-ТМ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Боловсролын ерөнхий газраас 118,874.1 мянган төгрөгийн ном, компьютер, ширээ сандал, Монголын боловсролын салбарын удирдах ажилтны холбооноос 16,416.3 мянган төгрөгийн зурагт, компьютерыг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан байна.

Аудитын гол асуудал

Дээд шатны төсвийн захирагчаас тус сургуулийн тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 9 удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 102 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 100.0 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.ЭНХТУЯА



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	244,268,639.34	191,952,423.20
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	139,055,473.50	92,005,980.53
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	139,055,473.50	92,005,980.53
31210	Төгрөг	139,055,473.50	92,005,980.53
31211	Төрийн сангийн харилцах	139,055,473.50	92,005,980.53
33	АВЛАГА	0.00	606,159.00
331	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	606,159.00
35	БАРАА МАТЕРИАЛ	105,213,165.84	99,340,283.67
35400	Хангамжийн материал	28,845,298.77	13,960,139.00
35450	Барилгын засварын материал	6,088,000.00	1,690,000.00
35470	Бусад хангамжийн материал	11,802,641.00	12,270,139.00
355	Биологийн хөрөнгө	10,954,657.77	0.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,754,637,761.70	1,868,271,848.01
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,754,637,761.70	1,868,271,848.01
39200	Биет хөрөнгө	1,288,391,511.84	1,400,961,848.01
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,224,744,512.01	1,224,744,512.01
39202	Хуримтлагдсан элэгдэл	(172,113,116.76)	(207,020,846.52)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	261,195,836.24	322,734,603.64
39206	Хуримтлагдсан элэгдэл	(136,056,059.05)	(63,340,231.16)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	72,711,593.67	62,036,446.07
39208	Хуримтлагдсан элэгдэл	(47,138,424.92)	(19,402,000.80)
39214	Бусад үндсэн хөрөнгө	89,748,149.47	89,748,149.47
39215	Хуримтлагдсан элэгдэл	(22,197,527.40)	(26,637,032.88)
39217	Ном	17,496,548.58	18,098,248.18
39300	Биет бус хөрөнгө	466,246,249.86	467,310,000.00
39301	Програм хангамж	1,650,000.00	1,400,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,403,750.14)	(90,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	466,000,000.00	466,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,998,906,401.04	2,060,224,271.21
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,998,906,401.04	2,060,224,271.21
51	Засгийн газрын хувь оролцоо	1,998,906,401.04	2,060,224,271.21
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,200,326,267.55	1,200,326,267.55
51200	Хуримтлагдсан үр дүн	-273,585,564.71	-212,267,694.54
51210	Өмнөх үеийн үр дүн	(273,585,564.71)	(273,585,564.71)
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	61,317,870.17
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,072,165,698.20	1,072,165,698.20
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,998,906,401.04	2,060,224,271.21

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН /төгрөгөөр/
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,505,231,273.82	1,938,198,653.51
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	58,045,819.80	192,894,847.20
120	Нийтлэг татварын бус орлого	58,045,819.80	192,894,847.20
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,668,988.00	9,887,900.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,668,988.00	9,887,900.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	17,506,504.50	159,992,969.60
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	32,870,327.30	23,013,977.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,447,185,454.02	1,745,303,806.31
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,330,012,400.00	1,638,445,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,330,012,400.00	1,638,445,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,000,000.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	115,173,054.02	106,858,406.31
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	115,173,054.02	106,858,406.31
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,419,222,850.00	1,876,880,783.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,419,222,850.00	1,876,880,783.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,339,794,950.00	1,824,790,283.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	926,127,107.33	1,368,609,800.26
210101	Үндсэн цалин	624,895,029.06	802,333,190.44
210102	Нэмэгдэл	261,976,703.27	485,549,444.37
210103	Унаа хоолны хөнгөлөлт	39,255,375.00	80,727,165.45
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	114,374,455.44	163,418,278.45
210201	Тэтгэврийн даатгал	79,730,925.63	109,997,272.42
210202	Тэтгэмжийн даатгал	9,196,857.28	13,736,877.61
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,291,602.23	6,843,888.83
210204	Ажилгүйдлийн даатгал	1,680,855.17	6,535,920.56
210205	Эрүүл мэндийн даатгал	16,474,215.13	26,304,319.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	103,140,454.02	98,969,056.31
210301	Гэрэл, цахилгаан	7,339,014.02	8,494,766.31
210302	Түлш, халаалт	87,681,900.00	80,429,400.00
210303	Цэвэр, бохир ус	8,119,540.00	10,044,890.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,059,685.65	10,954,657.77

210408	Бараа материал акталсны зардал	13,059,685.65	10,954,657.77
2105	Нормативт зардал	0.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	32,885,200.00	12,287,350.00
210604	Урсгал засвар	32,885,200.00	12,287,350.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,500,300.00	24,356,262.26
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,120,300.00	3,719,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,380,000.00	20,636,362.26
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	141,707,747.56	146,194,878.25
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,014,998.92	50,201,595.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,734,500.00	14,321,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	101,958,248.64	81,671,783.25
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	79,427,900.00	52,090,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	79,427,900.00	52,090,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	47,601,000.00	52,090,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	31,826,900.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	86,008,423.82	61,317,870.21
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	86,008,423.82	61,317,870.21

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

		/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,454,854,442.02	1,755,191,706.31
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,668,988.00	9,887,900.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,668,988.00	9,887,900.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,668,988.00	9,887,900.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,668,988.00	9,887,900.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,447,185,454.02	1,745,303,806.31
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,330,012,400.00	1,638,445,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,330,012,400.00	1,638,445,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,000,000.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	115,173,054.02	106,858,406.31
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	115,173,054.02	106,858,406.31
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,285,805,900.71	1,766,928,299.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,285,805,900.71	1,766,928,299.28

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,206,378,000.71	1,714,837,799.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	926,127,107.33	1,369,215,959.26
210101	Үндсэн цалин	624,895,029.06	802,939,349.44
210102	Нэмэгдэл	261,976,703.27	485,549,444.37
210104	Урамшуулал	39,255,375.00	80,727,165.45
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	114,374,455.44	163,418,278.45
210201	Тэтгэврийн даатгал	79,730,925.63	109,997,272.42
210202	Тэтгэмжийн даатгал	9,196,857.28	13,736,877.61
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,291,602.23	6,843,888.83
210204	Ажилгүйдлийн даатгал	1,680,855.17	6,535,920.56
210205	Эрүүл мэндийн даатгал	16,474,215.13	26,304,319.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	103,140,454.02	98,969,056.31
210301	Гэрэл, цахилгаан	7,339,014.02	8,494,766.31
210302	Түлш, халаалт	87,681,900.00	80,429,400.00
210303	Цэвэр, бохир ус	8,119,540.00	10,044,890.00
2105	Нормативт зардал	0.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,032,600.00	7,889,350.00
210604	Урсгал засвар	12,032,600.00	7,889,350.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,500,300.00	24,356,262.26
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,120,300.00	3,719,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,380,000.00	20,636,362.26
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,203,083.92	50,988,893.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,580,583.92	36,667,393.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,622,500.00	14,321,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	79,427,900.00	52,090,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	79,427,900.00	52,090,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	47,601,000.00	52,090,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	31,826,900.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	169,048,541.31	(11,736,592.97)
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	0.00	0.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	48,067,600.00	35,312,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	48,067,600.00	35,312,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	48,067,600.00	35,312,900.00
222001	Тоног төхөөрөмж	48,067,600.00	35,312,900.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(48,067,600.00)	(35,312,900.00)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00

VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	120,980,941.31	(47,049,492.97)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		139,055,473.50
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		92,005,980.53

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,200,326,267.55	1,072,165,698.20	-359,593,988.53	1,912,897,977.22
7	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	86,008,423.82	86,008,423.82
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,200,326,267.55	1,072,165,698.20	-273,585,564.71	1,998,906,401.04
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	61,317,870.17	61,317,870.17
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,200,326,267.55	1,072,165,698.20	-212,267,694.54	2,060,224,271.21

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/					
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,924,483,600.00	1,802,241,199.28	122,242,400.72	93.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,924,483,600.00	1,766,928,299.28	157,555,300.72	91.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,865,831,900.00	1,714,837,799.28	150,994,100.72	91.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,421,163,000.00	1,369,215,959.26	51,947,040.74	96.3
210101	Үндсэн цалин	883,144,500.00	802,939,349.44	80,205,150.56	90.9
210102	Нэмэгдэл	474,092,500.00	485,549,444.37	(11,456,944.37)	102.4
210104	Урамшуулал	63,926,000.00	80,727,165.45	(16,801,165.45)	126.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	177,645,400.00	163,418,278.45	14,227,121.55	92.0
210201	Тэтгэврийн даатгал	120,798,900.00	109,997,272.42	10,801,627.58	91.1
210202	Тэтгэмжийн даатгал	14,211,700.00	13,736,877.61	474,822.39	96.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,105,800.00	6,843,888.83	261,911.17	96.3
210204	Ажилгүйдлийн даатгал	7,105,800.00	6,535,920.56	569,879.44	92.0
210205	Эрүүл мэндийн даатгал	28,423,200.00	26,304,319.03	2,118,880.97	92.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	131,470,700.00	98,969,056.31	32,501,643.69	75.3

210301	Гэрэл, цахилгаан	9,356,400.00	8,494,766.31	861,633.69	90.8
210302	Түлш, халаалт	108,188,700.00	80,429,400.00	27,759,300.00	74.3
210303	Цэвэр, бохир ус	13,925,600.00	10,044,890.00	3,880,710.00	72.1
2105	Нормативт зардал	0.00	0.00	0.00	
210502	Хоол, хүнс	0.00	0.00	0.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,892,600.00	7,889,350.00	3,250.00	100.0
210604	Урсгал засвар	7,892,600.00	7,889,350.00	3,250.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	37,441,800.00	24,356,262.26	13,085,537.74	65.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,719,900.00	3,719,900.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	33,721,900.00	20,636,362.26	13,085,537.74	61.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	90,218,400.00	50,988,893.00	39,229,507.00	56.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	75,896,900.00	36,667,393.00	39,229,507.00	48.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,321,500.00	14,321,500.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,651,700.00	52,090,500.00	6,561,200.00	88.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	58,651,700.00	52,090,500.00	6,561,200.00	88.8
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	58,651,700.00	52,090,500.00	6,561,200.00	88.8
	Дотоод эх үүсвэрээр	0.00	35,312,900.00	(35,312,900.00)	
222001	Тоног төхөөрөмж	0.00	35,312,900.00	(35,312,900.00)	
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,924,483,600.00	1,755,191,706.31	169,291,893.69	91.2
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,777,808,700.00	1,745,303,806.31	32,504,893.69	98.2
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,638,445,400.00	1,638,445,400.00	0.00	100.0
	Орон нутгийн төсөв	139,363,300.00	106,858,406.31	32,504,893.69	76.7
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	146,674,900.00	9,887,900.00	136,787,000.00	6.7
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,887,900.00	9,887,900.00	0.00	100.0
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	136,787,000.00	0.00	136,787,000.00	0.0
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		139,055,473.50	0.00	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		92,005,980.53	0.00	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Мандал сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь “Сургуулийн менежментийг сайжруулж, хүүхдийн суралцахуйн болон төлөвшлийн хөгжилд ахиц гаргах, оролцоог дэмжих” гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлсэн байна

Хичээлийн жилд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Сургуулийн менежментийг сайжруулж үнэлгээний үр дүнд суурилан, сурлагын амжилтыг ахиулах,
- Суралцагчдыг гадаад хэл шинжлэх ухаан, технологи, математик болон цахим платформд суурилсан нэмэлт хөтөлбөрт хамруулан бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, шинжлэн судлах арга барил эзэмшүүлэх,
- Хүүхдийн хөгжил-хамгаалал-сэтгэл зүйн үйлчилгээний цогц арга зүйг хөгжүүлэх
- Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургах, тэгш боломж олгох орчныг бүрдүүлж, тэдний онцлог, хэв маягт тохирсон ганцаарчилсан хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх
- Багшийн хөгжилд дэмжлэг үзүүлэх, хамтын үйл ажиллагаа- манлайллыг хөгжүүлэх, нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэх, ёс зүйн хэм хэмжээ шаардлагыг эрхэмлэх манлайлах

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;*
- *Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 84 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй

боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мандал сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мандал сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 61,317.8 мянган төгрөгөөр буюу 2.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөгөөр/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	139,055.5	92,006.0	(47,049.5)
Авлага		606.1	606.1

Бараа материал	105,213.2	99,340.3	(5,872.9)
Үндсэн хөрөнгө	1,754,637.8	1,868,271.8	113,634.0
Нийт хөрөнгө	1,998,906.4	2,060,224.2	61,317.8
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,998,906.4	2,060,224.2	61,317.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,998,906.4	2,060,224.2	61,317.8

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 92,006.0 мянган төгрөг болж 47,049.5 мянган төгрөгөөр буурсан нь мөнгөн хөрөнгийн зарцуулалттай холбоотойгоор ,
- Авлага дансны үлдэгдэл 606.1 мянган төгрөг өссөн нь ХХОАТ-ын татварыг илүү шилжүүлснээс
- Бараа материал дансны үлдэгдэл 99,340.3 мянган төгрөг болж 5,872.9 мянган төгрөгөөр буурсан нь БЕГ-аас 7,214.0 мянган төгрөгийн ном, 15,800.0 мянган төгрөгийн барилгын засварын материалыг үнэ төлбөргүй авч, төсвийн хөрөнгөөр 90,644.3 мянган төгрөгийн худалдан авалт хийж, үйл ажиллагаанд 108,576.6 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулан, сургуулийн захирлын 2024 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн А/27 дугаар тушаалын дагуу цаашид ашиглах боломжгүй 10,954.6 мянган төгрөгийн бараа материалыг акталж данс бүртгэлээс хассанаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 2,184,762.0 мянган төгрөг болж 51,215.3 мянган төгрөгөөр өссөн нь БЕГ-аас 601.7 мянган төгрөгийн ном, 118,874.1 мянган төгрөгийн компьютер, принтер, ширээ сандал, Монголын боловсролын салбарын удирдах ажилтны холбооноос 16,416.3 мянган төгрөгийн компьютер, зурагт үнэ төлбөргүйгээр хүлээн авч, аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 453 дугаар албан бичгээр ашиглалтын хугацаа нь дууссан, анхны өртгөө нөхсөн цаашид ашиглах боломжтой 32,802.6 мянган төгрөгийн хөрөнгийг 24,100.8 мянган төгрөгөөр дахин үнэлж бүртгэсэн, төсвийн хөрөнгөөр 35,312.9 мянган төгрөгийн принтер, компьютер худалдан авсан, сумын ИТХ-ын 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 153 дугаар тогтоолоор 111,288.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил акталж данснаас хассан, 81,671.8 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос тус тус шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд улсын төсвөөс 1,200,136.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 151,255.7 мянган төгрөг зэрэг нийт 1,351,391.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийн саналыг цалин, НДШ-н зардлыг 48,862.9 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 49,239.0 мянган төгрөгөөр нийт 98,101.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшууллын зардлыг 47,340.9 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 12,240.0 мянган төгрөгөөр нийт 59,580.9 мянган төгрөгөөр буруулж нийт 1,389,912.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд төсөвт 9 удаа төсвийн зохицуулалт хийж цалин, НДШ-ийн зардлыг 491,536.8 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 9,063.2 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 2,519.9 мянган төгрөгөөр, мэдээллийн технологийн зардлыг 25,538.2 мянган төгрөгөөр, төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшууллын зардлыг 5,912.6 мянган төгрөгөөр нийт 534,570.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж улсын төсвөөс 1,638,445.4 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 139,363.3 мянган төгрөгийн, үндсэн үйл ажиллагааны орлогоос 9,887.9 мянган төгрөгийн урьд оны үлдэгдлээс 136,787.0 мянган төгрөг зарцуулахаар төсвийг нийт **1,924,483.6** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсний дагуу нийт 1,924,483.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 1,802,241.2 мянган төгрөгийг зарцуулж, 122,242.4 мянган төгрөгийг хэмнэж үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,802,241.2 мянган төгрөг буюу 93.6 хувьтай байгаа нь үдийн цайны зардал 6,561.2 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны зардлыг 115,681.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

<i>/мянган төгрөгөөр/</i>							
Д/Д	Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Биелэлт
1	71802 Ерөнхий боловсрол	1	80226- Байр ашиглалтын үйлчилгээ	3,954.80	3,833.70	121.10	96.9
		2	80312- Сургалт семинар	2,421.10	2,420.90	0.20	100.0
		3	81605- Эрүүл мэндийг дэмжих	3,580.60	3,576.00	4.60	99.9
		4	81801- Үдийн цай хөтөлбөр	58,651.70	52,090.50	6,561.20	88.8
		5	81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	30,984.00	30,963.00	21.00	99.9

6	81823- Боловсролын багшийн сургалт	10,753.00	5,660.00	5,093.00	52.6
7	81834- Боловсролын стандарт сургалт	1,586,680.50	1,510,211.60	76,468.90	95.2
8	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	69,598.80	69,556.40	42.40	99.9
9	81848-Сурах бичгийн түрээс	3,719.90	3,719.90	0.00	100.0
10	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	139,363.30	106,858.40	32,504.90	76.7
11	81875-Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	5,022.40	3,609.60	1,412.80	71.9
12	81844-Гүнзгийрүүлсэн төрөлжсөн	6,168.10	6,156.80	11.30	99.8
13	80233-Хүүхэд хамгаалал	3,585.40	3,584.40	1.00	100.0
Нийт		1,924,483.60	1,802,241.20	122,242.40	93.6

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайланг худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулан хоол хүнсний 52,739.1 мянган төгрөгийн, мэдээлэл технологийн зардлын 26,256.0 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээг гүйцэтгэх бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтыг зарласан боловч гүйцэтгэгч ирээгүй учраас “Шанзан ташуур”, “Амьд шим” хоршоо, “Япсомо” ХХК-иудтай шууд гэрээ байгуулан, худалдан авалтыг хийж гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Мандал сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан,

төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарын аудитор Ц.Уртнасан гүйцэтгэж анхан шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мандал сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарт 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “бага” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,419,222.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 14,192.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Мандал сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн системийн мэдээлбэл зохих 20 төрлийн 171 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 173 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэлгүйгээр 9 багшид 397.5 мянган төгрөгийг илүү олгосон зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосон байна.

Актын биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт тогтоох	1	397.5	1	397.5	100.0
Нийт дүн	1	397.5	1	397.5	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой дараах 1,212.2 мянган төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

1. ХХОАТ-ын илүү шилжүүлсэн 606.1 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй,
2. Үр дүнгийн тайланд цалингийн зардлыг 606.1 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 14 дүгээр зүйлийн 14.4. Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.1-д “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.3-т “бүх өр төлбөр” гэсэн заалтуудыг т зөрчсөн байна.

Аудитаар нийт 606.1 мянган төгрөгийн зөрчил илэрч 1 албан шаардлага, хүргүүлээ.

5.1 Албан шаардлага

1. Төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 606.1 мянган төгрөгийн ХХОАТ-ийн авлага үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Санхүүгийн тайланд авлага тусгаагүй	1	606.1	1	606.1			1	606.1				
Цалингийн зардал илүү тайлагнасан	1	606.1			1	606.1	1	606.1				
Дүн	2	1,212.2	1	606.1	1	606.1	2	1,212.2				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Авлага үүсгэсэн	1	606.1			1	606.1						
Дүн	1	606.1			1	606.1						

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.